

## Мэдээллийн гэрэл зурагт тайлбар чухал болох нь

Чулуунбаатарын Энхбат 

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн багш, доктор (Ph.D), Улаанбаатар, Монгол Улс

Хүлээн авсан - Received:  
2023-11-21

Засварласан - Revised:  
2023-12-05

Хэвлэгдсэн - Published:  
2023-12-26

enkhbat.ch@msue.edu.mn

ORCID: [0009-0003-2678-5619](https://orcid.org/0009-0003-2678-5619)



© 2023, Author(s)

**Хураангуй.** Гэрэл зураг нь сэтгүүл зүйн мэдээлэлд чухал ач холбогдол бүхий баримт байдаг. Гэтэл Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь мэдээллийн гэрэл зурагт төдийлөн ач холбогдол өгөхгүй байгаа дүр зураг ажиглагдах болов. Иймд бид судалгааныхаа хүрээнд өдгөө эрчимтэй хөгжиж буй мэдээллийн шинэ хэрэгсэл болох сайтуудад нийтлэгдсэн мэдээллийн гэрэл зургуудад ажиглалт хийж үнэлэлт дүгнэлт өглөө.

**Түлхүүр үг:** *Фото сэтгүүлч, гэрэл зургийн сэтгүүл зүй, тайлбаргүй гэрэл зураг, агуулга, гэрэл зургийн ач холбогдол*

Хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж буй гэрэл зургийн сэтгүүлчид мэргэжлийн шаардлагаар өөрсдийн гэрэл зураг, сэдвийнхээ талаар тайлбар, дэлгэрэнгүй мэдээлэл өгдөг байх нь хүлээлт байсаар ирэв.

Сэтгүүл зүйд гэрэл зураг онцгой ач холбогдолтой. Тэгвэл сэтгүүл зүй дэх мэдээллийн гэрэл зурагт тайлбар чухал юм. Гэрэл зураг нь мэдээ мэдээлэлд хөдөлшгүй баримт болж байдаг. Тиймдээ ч зөвхөн нэг гэрэл зургаар ойлгомжгүй мянган текстийг ч орлуулах боломжтой хэмээдэг. Түүнчлэн гэрэл зураг нь ямар ч боловсролын төвшний уншигч, үзэгч харах байдлаар мэдээллийг шууд хүртэх боломжтой зэрэг давуу тал олон. Гэрэл зураг сэтгүүл зүйн бичвэрийг баяжуулахаас гадна тухайн нийгмийн тусгал нь болдог. Иймд гэрэл зургийн мөн чанар хамгийн чухал аж.

Тайлбар бол юуны өмнө зургийн агуулга, утга гэдгийг сануулмаар байна. Зургийн тайлбарт юуны тухай өгүүлэх вэ, юуг онцолбол илүү вэ гэдэгт хариулах амаргүй ч “дүр дүрслэлд буй утгыг бүү давт” гэсэн зарчмыг баримтлах нь чухал (Болд-Эрдэнэ, 2004) гэдгийг олон судлаач тэмдэглэдэг. Тайлбарын “...шрифтийн илэрхийлэл, сонголтын хувьд гэрэл зураг болоод бичвэрийн аль алианаас ялгагдахуйц байх ёстой. Тайлбар нь гэрэл зургаас агаарын оролцоо, байгуулалтын зохиомжоор ялгагддаг бол бичвэрээс шрифтийн хэлбэр нимгэн зузаан налуу эсэхээр анги өөр

байдлыг илэрхийлдэг.Тайлбар нь гэрэл зургийн дор, зэрэгцсэн болоод зарим тохиолдолд хоёр зургийн хооронд байгуулж болно (Болд-Эрдэнэ, 2004).

Ерөнхийдөө гэрэл зургийн тайлбар нь тухайн зургийнхаа төрлөөс хамаараад агуулгын хувьд өөр байх боломжтой. Тухайлбал, хөрөг зургийн тайлбар нь тухайн эх сурвалжийн овог нэрээс гадна гэрэл зураг авхуулсан цаг хугацаа, хаана авхуулсан зэрэгт хариулж болох юм. Гэтэл олон нийтийн хэсгийг хамарсан гэрэл зургийн тухайд үйл явдал, орчин нөхцөлийг нь тайлбарлахаас гадна ихэвчлэн тухайн гэрэл зурагт багтсан эх сурвалжуудын овог нэр, албан тушаалыг тайлбарласан өнгө аястай байх боломжтой.

Түүнчлэн мэдээллийн гэрэл зурагт тайлбар өгөхдөө тухайн бичвэр, мэдээллийн агуулгад орсон баримт, эшлэлээс сонирхолтойг нь сонгож өгч болдог байна.

Тогтмол хэвлэлд нийтлэгдсэн мэдээллийн гэрэл зураг болон түүний тайлбар нь хожим нь түүхийн баримт бичиг ч болдог. Учир нь олон арван жилийн өмнө хэвлэн нийтлэгдсэн мэдээ мэдээллээс түүхийн эх сурвалж болгосон тохиолдолд тухайн гэрэл зураг нь тайлбаргүй бол бусдын дунд маргаан, будилаан үүсгэхийг үгүйсгэхгүй. Жишээлбэл, Монголын ардчилсан хувьсгалаас өмнөх үеийн хэвлэлд нийтлэгдсэн Ардын их хурлын үйл явдлын зурагт хуралд оролцсон хүмүүсийн зураг байлаа гэхэд хэрэв тайлбаргүй нийтлэгдсэн бол ямар албан тушаалтнууд байна вэ гэдэг нь тодорхойгүй үлдэх боломжтой юм. Ийм зэрэг байдлаар гэрэл зурагт тайлбар өгөх нь тал талын ач холбогдолтой болно.

Фото сурвалжлагч, сэтгүүлч хоёрын дунд гэрэл зургийн тайлбар нь орхигдох нь бий. Монголын сэтгүүл зүйд гэрэл зургийн сурвалжлагч зөвхөн зургаа авдаг, харин сэтгүүлч нь зөвхөн текстээ бичих нь түгээмэл. Тиймээс хамтарч баг болон ажиллаж, тухайн гэрэл зурагт ямар тайлбар өгөх нь орхиж үл болох ажлын нэгээхэн чухал хэсэг мөн. Гэхдээ, мэдээж мэдээллийн гэрэл зурагт санаатай болоод санамсаргүй байдлаар буруу, ташаа тайлбар өгөх нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ёс зүйд харш гэдгийг байнга санах хэрэгтэй. Ямар нэгэн байдлаар алдаатай, ташаа тайлбар өгсний улмаас нийгэмд залруулж боломгүй хохирол учруулах эрсдэлтэй юм.

Хэвлэл мэдээллийн салбарынхан дунд өөр нэг түгээмэл ойлголт нь олны танил, хүн бүр мэддэг гэх ойлголтоор зарим хөрөг зурагт өгүүлсэн эх сурвалжийн нэрийг заалгүй орхигдуулдаг. Гэтэл улсын ерөнхийлөгч, олны танил од ч байсан хамаагүй овог нэр, албан тушаалыг нь зургийн тайлбарт оруулах нь зохистой юм. Учир нь тухайн сонин сэтгүүл, сайтын мэдээллийг өөр улс орны уншигчид хүртэл орчуулаад унших нь бий. Тиймээс олны танил хүн гэлтгүй тухайн албан тушаалтны овог нэр, албан тушаалыг тайлбарын өгөгдөлд тусгадаг байх нь зүйтэй. Түүнээс гадна дан ганц тайлбараас гадна гэрэл зургийг авсан гэрэл зургийн сурвалжлагчийн нэрийг орхигдуулах нь зохисгүй. Монголын мэдээллийн хэрэгслүүд зарим тохиолдолд хэн

авсан нь тодорхойгүй гэрэл зургийг авч хэвлэн нийтлэх нь түгээмэл байдаг. Энэ нь бас учир дутагдалтай тул ямар нэг байдлаар дурдах ёстой.

Орчин үед хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, ялангуяа шинэ мэдээллийн хэрэгслүүд нуршсан урт текстээс илүү гэрэл зураг, дүрс бичлэгт, богино текст зэрэгт ач холбогдол өгөх болсон. Хэдий гэрэл зурагт түлхүү ач холбогдол өгч байгаа ч тайлбар гэдэг зүйлийг орхигдуулж байгаа нь учир дутагдалтай юм. Гэтэл гэрэл зураг ялангуяа мэдээллийн гэрэл зурагт тайлбар бичих нь бүхнээс чухал төдийгүй мэдээний гэрэл зурагчны ажлын чухал хэсэг болно. Гэрэл зургийн тайлбар нь ихэвчлэн унших ёстой нийтлэлийн эхний элементүүд байдаг.

Тайлбар гэх үгийн утгыг “Утга агуулга, учир шалтгааныг дэлгэрүүлэн тайлж хэлсэн ба бичсэн зүйл” (Баярсайхан, 2009) гэжээ. Мөн зургийн тайлбарыг “зургийг хаана, хэзээ, хэнтэй, яагаад авхуулах болсон тухай үзэгчдэд нэмэлт мэдээлэл өгөх зорилгоор хийсэн тайлбар” (Баярсайхан, 2009) хэмээн тайлбарласан байна.

Сэтгүүл зүйн бичвэрүүд хэл найруулгынхаа хувьд боловсролын түвшний бүхий л хүмүүст ойлгомжтой байдагтай адил фото сэтгүүл зүйд ч ялгаагүй ямар нэгэн үйл явдлын зургийг мэдээллийн багтаамжтайгаар хэвлэн нийтлэхдээ газар орон, орчны байршил болон хөрөг зураг зэрэгт олны танил хэнбугай ч бай зургийн дор нэр, тайлбарыг нь дурдах нь чухал баримт мэдээлэл болдог. Хэрэв бид хэвлэлийн нүүрээс тайлбаргүй зураг хараад урьд өмнө харж байгаагүй бол гайхаад, эсвэл цааш хуудсыг эргүүлдэг. Ямар нэгэн байдлаар тайлбарыг орхигдуулбал фото сурвалжлагчийн хувьд алдаа болох юм. Мөн ур чадвартай нь ч шууд холбогдоно. Учир нь өөрийн цаг заваа зарцуулан байж авсан гэрэл зурагтаа ямар нэг тайлбар өгөөгүйгээс болоод тухайн бүтээл тань үнэгүйднэ гэсэн үг. Нэгэнт хэвлэн нийтлэгдсэн гэрэл зургийн тайлбарыг дараа нь дахин засварлан оруулах боломжгүй.

Ихэнх зургийн тайлбарт эхний өгүүлбэрт тухайн зураг дээрх хүмүүс, газар, мөн авсан огноо, байршилыг тодорхойлдог. Хоёр дахь (магадгүй гурав дахь) өгүүлбэр нь уншигчдад юу харж байгааг ойлгоход нь туслах контекст мэдээлэл өгөх ёстой. Харамсалтай нь Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд гэрэл зурагтаа тодорхой хэмжээнд ач холбогдол өгдөг хэдий ч тайлбар гэдэг зүйлийн мөн чанар, ач холбогдлыг нь сайн ойлгоогүй, ойлгодоггүй мэт дүр зураг ажиглагдаж байна.

Тайлбар бичихдээ тодорхой, үнэн зөв, бүрэн дүүрэн байх мэргэжлийн стандарт нь хэвлэлд гарч буй бусад бичвэртэй адил байх ёстой. Мэдээлэлгүй, эсвэл муу, төөрөгдүүлсэн тайлбар нь сайн зургийн нөлөөллийг бууруулж, сэтгүүл зүйн үнэлэмжийг алдагдуулж болзошгүй юм. Хэрэв уншигчид тайлбарт оруулсан энгийн мэдээллийн үнэн зөв байдалд итгэхгүй байгаа бол бусад нийтлэлээс уншсан зүйлдээ итгэх боломж хомс.

Зарим тохиолдолд гэрэл зургийн тайлбарт хамааралгүй текстийг техникийн алдааны үүднээс оруулсан байх нь бий. Энэ нь гэхдээ техник алдаа учир залруулах боломжтой. Харин тухайн гэрэл зурагт өгөгдсөн эх сурвалж, орчны талаар бичихдээ ямар нэгэн байдлаар нэр усыг нь ташаа мэдээлэх нь сэтгүүлчийн судалгаа, ур чадвар, баримтыг нягтлах зэрэгтэй шууд хамаарна.

Зургийн тайлбар нь уншигчдад гэрэл зураг, түүний мэдээтэй холбоотой байдлыг ойлгоход шаардлагатай үндсэн мэдээллийг өгдөг. Тухайн гэрэл зурагт тайлбар, мэдээлэл өгөхдөө сэтгүүл зүйн бичвэрт тавигддаг шаардлагын дагуу сунжирсан биш, товч, ойлгомжтой хэлбэрээр бичих нь зохимжтой юм.

Мэдээллийн гэрэл зурагт дараах байдлаар тайлбар өгөх нь зөв зүйтэй. Зураг дээр гарч буй хүмүүс, байршлыг тодорхой зааж өгөх. Байршлын албан ёсны нэрээс гадна мэргэжлийн цол хэргэмийг оруулах ёстой. Нэрийг зөв бичих (шаардлагатай бол нийтлэл дэх зөв бичгийн алдааг шалгана уу). Нэгээс олон хүний гэрэл зургийн хувьд таних тэмдэг нь ихэвчлэн зүүнээс баруун тийш явдаг. Том бүлгүүдийн хувьд зөвхөн олны танил хүмүүсийг тодорхойлох шаардлагатай байж болох бөгөөд заримдаа таних тэмдэг огт шаардлагагүй байдаг. Түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд өөрийн гэсэн гэрэл зурагчдынхаа стандартыг бий болгох нь оновчтой юм.

Тухайн гэрэл зургийг авсан он сар өдрийг оруулах нь мэдээллийн гэрэл зурагт зайлшгүй шаардлагатай баримт юм. Зураг нь хэдий чинээ шинэ байх тусмаа сайн. Архивын гэрэл зураг эсвэл үйл явдлыг дүрслэхээс өмнө авсан гэрэл зургийг ашигласан бол тайлбар нь “файлын зураг” гэдгийг тодорхой болгох ёстой. Учир нь гэвэл сэтгүүл зүй бол шинэ баримтыг мэдээлдэг болохоос биш өнгөрсөн, хуучин зүйлийг мэдээлэх ёсгүй билээ. Үүний адил мэдээллийн гэрэл зурагт ч тус шаардлага тавигдана. Жишээлбэл, тогтмол хэвлэлд ярилцлага бичвэрт тухайн эх сурвалжийнхаа таван жил, бүр арван жилийн өмнө авхуулсан зургийг тайлбаргүй байдлаар оруулсан нь байдаг. Угтаа тухайн зурагтаа тайлбар байдлаар гэрэл зургийг авхуулж байсан оныг нь дурдах нь зүйн хэрэг. Нөгөө талаараа ярилцлагын зочны яг одоо цагт авхуулсан зургийг оруулаагүй байгаа нь сэтгүүлчийн ажлын ур чадвар зэргийг илтгэх юм.

Уншигчдад мэдээллийн гэрэл зургийн үнэ цэнийг нь ойлгуулахын тулд түүнд зарим нэг контекст эсвэл суурь мэдээлэл өг. Ихэвчлэн ганц хоёр өгүүлбэрээр тайлбар өгөх нь оновчтой юм. Энэ нь нөгөө л сэтгүүл зүйн бичвэрийн товч, тодорхой байхтай хамаарна. Ихэнх тайлбар нь нэг эсвэл хоёр богино, тунхаг өгүүлбэр байна. Зарим нь зургийг бүрэн тайлбарлахын тулд нарийн төвөгтэй контекст мэдээлэл шаардлагатай бол гурав дахь өгүүлбэр хүртэл сунгаж болно.

Өөр нэг чухал нь зургийн тайлбарыг бүрэн өгүүлбэрээр, одоо цагт бичнэ. Одоогийн цаг нь дүр төрхийн ойрын мэдрэмжийг өгдөг. Тайлбарыг бүхэлд нь одоо

цагт бичих нь уялдаа холбоогүй тохиолдолд эхний өгүүлбэр нь одоо цагт бичигдсэн байгаад дараагийн өгүүлбэрүүдийг өнгөрсөн цагт бичих боломжтой.

“Ассошэйтэд Пресс” агентлаг л гэхэд сурвалжлагчдадаа гэрэл зургийн тайлбар сонирхолтой, нягт, нямбай, ямагт өөдрөг, амьд сэтгэлтэй байх ёстой гэж зөвлөдөг ажээ. Тус агентлагийн Удирдах зөвлөлийн сургалтын хэлтсээс гэрэл зургийн сайн тайлбарт тавигдах шаардлагыг дараах байдлаар гаргажээ. Үүнд, бүрэн төгс, тодорхой, Хэзээ?, Хаана? гэсэн асуултад хариулж байгаа эсэх, зурагт юуг өгүүлж байгааг хэлэх, зурагт орсон хүмүүсийн нэрсийг зөв байрлуулж, алдаагүй бичсэн эсэх, бусдаас онцлог байх, уншихад хялбар дөхөм, тэмдэг нэр аль болох цөөн байх, өөр гэрэл зургийг санал болгох (Менчир, 1996) гэсэн 10 зүйлийг тусгасан байна. Агентлагийн зүгээс “Гэрэл зургийг үзээгүй байж тайлбар бүү бич” гэх тулгуур зарчмыг баримталдаг аж.

Гэрэл зургийн тайлбарын өөр нэг ач холбогдол нь салбар салбарын шинэ боловсон хүчин, залуу уран бүтээлчдийг олон нийтэд таниулахад оршино. Хэвлэл мэдээллийн зүгээс зарим тохиолдолд олны танил хүн л юм чинь тайлбар, нэрийг нь зурагт оруулах шаардлагагүй гэсэн өрөөсгөл ойлголтоор орхигдуулах нь бий.

Гэвч хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэгдсэн төрийн өндөр албан тушаалтан эсвэл олны танил хүмүүс, энгийн иргэд зэрэг эх сурвалжийг уншигч, үзэгч, хэрэглэгч бүхэн таньдаг байх шаардлагагүй билээ. Сэтгүүл зүйг боловсролын төвшин ямар ч бай хүн бүр ойлгохуйц хэл найруулгаар олон нийтэд хүргэдэгтэй адил бид гэрэл зураг бүртээ тодорхой тайлбарыг өгч байх нь зүйтэй юм. Энэ нь эргээд фото сурвалжлагчийн ур чадвартай холбогдох зүйл билээ.

Зургийн тайлбар нь ихэвчлэн унших ёстой нийтлэлийн эхний элементүүд байдаг гэдгийг байнга санах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл тайлбар бичих нь мэдээний гэрэл зурагчны ажлын чухал хэсэг гэж тодорхойлж болно. Зургийн тайлбар нь уншигчдад гэрэл зураг, түүний мэдээтэй холбоотой байдлыг ойлгоход шаардлагатай үндсэн мэдээллийг өгөх ёстой. Мэдээллийн байгууллагууд зургийг хэвлэн нийтлэх цаг алдалгүй шилжүүлэх боломжийг олгодог тууштай, товч хэлбэрээр бичсэн байх ёстой.

Ямар нэгэн гэрэл зургийг хэрхэн ойлгож, хүлээн авах нь тухайн хүний мэдрэмж, ертөнцийн тухай ойлголттой салшгүй холбоотой. Хүн зургийн агуулгыг юун түүрүүнд өөртөө хамгийн ойр, ижил төстэй нөхцөл байдал юм уу субьекттэй холбож ойлгодог. Гэрэл зураг олон жижиг хэсгүүдээс бүрддэг. Түүнийг харж байгаа хүн тэр олон жижиг хэсгийг нэгдмэл нэг зүйл болгон хүлээн авдаг. Гэхдээ тэдгээр олон жижиг зүйлийг мөн тус бүрд нь салган ажиглаж болно.

Зургийг хүн хэрхэн хүлээж авах нь тухайн хүний амьдарч буй орчин, нийгмийн соёл, үнэт зүйлсээс ихээхэн шалтгаална. Зурагт багтаж буй зарим деталь хэсэг нь

тухайн зургийг сонирхож байгаа үзэгчдэд уг зургийн тайлбар нь болдог. Үзэгчид тухайн гэрэл зургийг дүгнэх байдлаар ажиглахаасаа илүү сэтгэл хөдлөл, хувийн үнэт зүйлс, үзэл бодлын үүднээс хандаж, хүлээн авдаг байна.

Тэгвэл мэдээллийн гэрэл зургийн тухайд үйл явдал, сэдэвтэй холбоотойгоор эх сурвалж, баримтыг хэвлэн нийтэлдэг тул үзэгч, уншигч өөрөө хараад ойлгохоос илүүтэй тухайн баримтат зургийг тайлбартай нийтлэх нь чухал юм. Учир нь сэтгүүл зүйн үүднээс үзвэл мэдээллийн гэрэл зураг нь SWIH-д мөн хариулт өгөхийг зорино. Харин тус зургаан асуултад хариулахад нь гэрэл зургийн тайлбар чухал нөлөө үзүүлэх юм.

Тиймээс гэрэл зургийг авч буй фото сэтгүүлч нь гэрэл зургийн өнцөг болоод агуулгыг хэрэн цогцлоох тал дээр гярхай байхыг шаардана. Гэрэл зураг нь угтаа орон зай, цаг хугацааны нэг л агшныг гарган ирж, түүнийгээ бусдаас ялгаруулахыг зорьдог. Гэрэл зургаас тухайн агшны өмнө, хойно, түүний хажуугаар, дээгүүр, доогуур юу болсныг мэдэх аргагүй. Тийм ч учраас гэрэл зургийг олон янзаар тайлбарлаж болдог. Тухайлбал, тухайн гэрэл зурагт чухам юу багтаахыг гэрэл зурагчин өөрөө л шийдвэрлэдэг. Гэрэл зургийн сэтгүүлч тухайн бодит байдлаас чухам аль агшныг нь, аль хэсгийг нь царцааж хальснаа буулгахаа мэднэ. Гэрэл зурагчин юуг чухал гэж үзсэн, тэр зүйл нь л зурагт бууна. Тийм учраас гэрэл зурагт сэтгүүлчийн /гэрэл зурагчны/ субъектив үзэл бодол төдийгүй тайлбар заавал орох шаардлагатай юм. Зарим тохиолдолд өөрийн зурагтаа чухал болон чухал биш, онцлог болон онцын хэрэггүй зүйлүүдийг гаргаж ирдэг. Харин хөндлөнгийн хүн зургаас нь үүнийг тэр болгон олж харж чаддаггүй. Тиймээс л тайлбар чухал болно.

Гэрэл зурагчны зураг авахдаа хэрэглэсэн зүйлс /гэрэл, дуран, филтер/, түүнийгээ дараа нь хэрхэн боловсруулсан /зургийн бэлтгэл, хэлбэр, саарал болон бусад өнгөний харьцааны зохицуулалт/ зэргээс шалтгаалан тухайн гэрэл зурагчин /эсвэл өөр хүн, жишээ нь редактор/ гэрэл зурагтаа өөрийн гэсэн хэлбэрийг бий болгодог. Энэхүү эцсийн хэлбэрийг нь хөндлөнгийн хүн /тухайлбал сонины уншигч/ хардаг. Тухайн уншигч, үзэгчийн юу харж байгааг уг зургийн агуулга гэнэ. Гэхдээ энэ нь ямагт субъектив зүйл байдаг. Иймд гэрэл зурагт тайлбар маш чухал үүрэгтэй. Тайлбарын тусламжтайгаар гэрэл зургийн олон утгыг бүдгэрүүлж, хэлэх гэсэн зүйлдээ анхаарал хандуулж болдог. Мөн гэрэл зураг нийтлэлийн нэгэн адил үнэн, худлыг өгүүлэх чадвартай юм. Гэхдээ бодит байдлыг зөвхөн физикийн аргаар цаасанд буулгадаг. Гэрэл зураг түүнийг харж байгаа хүнд эргэн тойрных нь тодорхой нэгэн дүр зургийг бий болгоно. Энэ зураг үнэн, эсвэл худал ч байж болно. Тухайн зургийг үзэж байгаа хүн үүний зөв, бурууг хэлэх боломжгүй юм. Тэгэхлээр тухайн зургаар гэрэл зурагчин чухам юуг илэрхийлж харуулах гэсэн, түүнийгээ хэрхэн яаж буулгаснаас их хамааралтай.

Мэдээллийн бус зургийн агуулгыг үгээр илэрхийлэх аргагүй юм. Хэрвээ тайлбарлах гэж оролдовол эхлээд нэг хэсгийг, дараа нь бас нэгэн өөр зүйлийг, ингээд дуусашгүй тайлбар хийх хэрэгтэй болох билээ.

Орчин үед мэдээллийн сайтын сэтгүүлчдийг олон талын чадвартай байхыг шаардаж буй. Тиймээс фото сэтгүүлч ч мөн тал талын чадварыг эзэмших нь чухал юм. Тухайлбал, өөрийн авсан гэрэл зурагтаа алдаагүй, товч тодорхой тайлбар өгчихдөг байх нь нэг төрлийн чадвар болно. Ур чадвараа гарган авсан гэрэл зурагтаа тайлбар өгөөгүй орхигдуулах нь тухайн бүтээлээ олон нийтэд хүргэж чадахгүйд хүрнэ. Мөн тухайн сайн гэрэл зургийг хэн авсан болохоо ч орхигдуулж болохгүй юм.

Гэрэл зургийн тайлбар тодорхой бус байж болохгүй, хүмүүс болон газрын нэрийг зөв тодорхойлж, зөв бичсэн эсэхийг шалгаарай. Гэрэл зургийн сэтгүүлч бол сэтгүүлч. Хэрэв зургийг хэмжээ, өнгөний хяналтаас хэтрүүлэн дижитал байдлаар өөрчилсөн бол тайлбар дээр “фото зураглал” гэж тэмдэглэнэ. Зургийн дарааллыг ашиглах гэх мэт тусгай эффектүүдэд тайлбар хэрэгтэй.

Тайлбар бичихдээ “дээрх зураг дээр байна” гэх мэт үйл үг, хэллэгийг бүү ашигла. Энэ нь ойлгомжтой, уйтгартай байдаг. Мөн зурган дээрх хэн нэгний бодож байгаа зүйлийн талаар найруулга, таамаглал бүү хий. Жишээлбэл, “аз жаргалгүй сонгогч...” эсвэл “азтай, амьд үлдсэн...” гэх мэт. Харин уншигчдад баримтуудыг өгч, ямар мэдрэмж, сэтгэл хөдлөлөө өөрөө шийдэх сонголтыг өг.

Зургийн агуулгыг үзэсгэлэнтэй, гайхалтай, аймшигтай эсвэл гэрэл зураг дээр илт харагдахуйц өөр ямар нэг дүрсэлсэн үгээр бүү тодорхойл.

Гэрэл зурагчид ихэвчлэн судалгаа хийж, арга хэмжээ болохоос өмнө хүлээгдэж буй оролцогчдын нэрсийг цуглуулдаг. Үүнд интернэт ашиглах нь тустай байж болно. Зарим фото сэтгүүлч үйл явдлын өмнө эсвэл үйл явдлын үеэр чөлөөт цагаараа тайлбараа бичиж эхэлдэг. Сайн зохион байгуулалттай арга хэмжээнүүдэд нэр хүндтэй оролцогчдын нэрсийг багтаасан хэвлэлийн мэдээнээс тайлбараа бичиж болдог. Гэсэн хэдий ч, тайлбарт шаардлагатай мэдээлэл нь зураг авахаас өмнө ихэвчлэн байдаггүй. Үйл явдлын үеэр тайлбарын мэдээлэл цуглуулах нь хэцүү бөгөөд гэрэл зурагчид үүнийг янз бүрийн аргаар эрэлхийлдэг. Ихэнх гэрэл зурагчид шаардлагатай мэдээллийг бичих жижиг дэвтэр авч явдаг. Орчин үед мэргэжлийн камерууд нь шаардлагатай мэдээллийг бичих боломжийг олгодог жижиг аудио бичигчтэй болсон. Мөн арга хэмжээнд оролцож буй бусад сэтгүүлч мэдээллийн эх сурвалж болох юм.

Цаг хугацаа өнгөрөх тусам гэрэл зурагчид тайлбарын мэдээллийг цуглуулахад хялбар болгох арга техник, цагийг боловсруулдаг. Загварт бичвэрийн адил гэрэл зурагчид ижил ерөнхий тайлбарыг ашиглах нь ч бий.

Сэдвийнхээ хүрээнд Монголын цахим сэтгүүл зүйд хандалтаараа тэргүүлж буй зарим сайтын гэрэл зургийн мэдээлэлд ажиглалт хийж үзлээ.

Ажиглалтын явцад хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь гэрэл зургийн сэтгүүлч нь зөвхөн зураг авах, хэвлэл мэдээллүүд нь авсан зургийг нь сонголтын дагуу шууд нийтлэх гэсэн байдал нийтлэг ажиглагдав. Жишээлбэл, хандалтаараа тэргүүлдэг “news.mn” сайтын 2023.11.29-ний өдөр нийтлэгдсэн “Томуугийн өвчлөл 0-15 насныхан дунд эрс нэмэгджээ” гэсэн гарчигтай сурвалжилгад эмнэлгийн орчинд авсан гурван гэрэл зураг нийтлэгдсэн байна. Эхний гэрэл зурагт эмнэлгийн хүлээн авах хэсэгт дараалан зогсож буй хүмүүсийн байдлыг царцаажээ. Эмнэлгийн орчноос сурвалжилга бэлтгэхдээ гэрэл зургийн сэтгүүлчийн тухайд ёс зүйгээ баримталж, аль болох хүний царай төрхийг зөвшөөрөлгүй нийтлэхээс зайлсхийдэг. Тус зургаас бол ёс зүйгээ баримталсан нь харагдаж байна. Харин тайлбарыг орхигдуулсан байна. Хоёр дахь гэрэл зурагт ХӨСҮТ-ийн мэдээллийн төвд мэдээлэл хийсэн эмнэлгийн гурван албан хаагчийн зургийг нийтэлжээ. Тус зурагт мөн л тайлбар байсангүй. Түүнчлэн бичвэр дунд хэн нэгэн эх сурвалжийн яриа байхгүй байгаа нь сурвалжилгын төдийгүй гэрэл зураг, текстийн харилцан хамаарлыг үгүй болгожээ. Харин гурав дахь гэрэл зураг мөн л тайлбаргүй бөгөөд мөн эмнэлгийн хүлээлгийн танхимын орчныг буулгасан байна. Харамсалтай нь энэ зурагт нэгэн эмэгтэй хүүхдээ тэврэн зогсож байгааг ямар нэгэн сарниулалтгүйгээр оруулжээ. Тэдний наад талын сандал дээр хүүхдээ хөхүүлж байгаа эмэгтэйн хөхний зургийг ч оруулсан нь ёс зүйн хувьд зохимжгүй аж. Энэ мэт байдлаар тус сайт нь гэрэл зурагт тайлбар өгдөггүй болох нь бусад бичвэрүүдтэй хамт нийтэлсэн гэрэл зургуудаас нь харагдаж байна.

Цахим сэтгүүл зүйд өөрийн гэсэн өнгө төрхийг тодорхойлоод буй Ikon.mn сайтын гэрэл зургийн мэдээллийг ажиглав. Тус сайт нь гэрэл зургийн МРА агентлагтай хамтарч ажилладаг бөгөөд зураг тус бүрийнхээ тайлбарын оронд “Гэрэл зургийг МРА агентлагийн онцгой зөвшөөрөлтэйгөөр ашиглав” гэжээ. Мөн л гэрэл зургуудаа тайлбаргүй мэдээлж байна. Бичвэрүүддээ гэрэл зураг олноор хавсаргаж оруулдаг ч огт тайлбаргүй байгаа нь гэрэл зургийн ач холбогдлыг орхигдуулдаг байна.

Мөн gogo.mn сайтын гэрэл зургийн мэдээллүүдийг үзэхэд мөн л дээрх хоёр сайтад гарсан алдаа дутагдал ажиглагдлаа. Тус сайт нь тодорхой сэдэв, асуудал, үйл явдлын хүрээнд фото сурвалжилга хэмээн тексттэй олон тооны гэрэл зургийг удаа дараа нийтэлжээ. Жишээлбэл, “Явган хүний зам дээр шахмал түлш зарж л байг уу?” гэсэн гарчигтай 16 зураг бүхий сурвалжилгыг 2023.11.29-ны өдөр нийтэлсэн байна. Дээрх 16 орчны зураг нь бүгд тайлбаргүй байв.

Ийнхүү бид мэдээллийн сайтуудад нийтлэгдсэн гэрэл зургууд тайлбаргүй байгааг монголын цахим сэтгүүл зүйд олон жил үйл ажиллагаа явуулан тодорхой байр суурийг эзэлсэн хандалт өндөртэй дээрх гурван сайтаас ажиглан, дүгнэв.



Дээрх гурван сайт нь гадаадын агентлагуудаас олон улсын мэдээллийг эх сурвалж болгодог ч тухайн мэдээллийнхээ текстийг анхаараад, гэрэл зургийнх нь тайлбарыг мөн оруулдаггүй байна.

Чөлөөт сэтгүүл зүй төлөвшсөн улс орнуудын мэдээллийн сайтуудыг ажиглаад үзэхэд гэрэл зургийн сэтгүүл зүйд ач холбогдол өгдөг болох нь ажиглагдлаа. Тухайлбал, олон улсын чанартай “bbc.com”, “apnews.com”, “reuters.com” зэрэг сайтын тухайд мэдээллийн гэрэл зураг болон видео мэдээллүүдээ ямар нэгэн байдлаар тайлбар өгдөг байна. Жишээлбэл, 2023.11.28-ны өдөр “reuters.com”-д нийтлэгдсэн “Израил, Хамас эвлэрлийг сунгах хүчин чармайлтын хүрээнд илүү олон хүнийг суллах болно” гарчигтай бичвэрийн гэрэл зурагт “2023 оны 11-р сарын 28-ны өдөр Израилын эзэлсэн Баруун эрэг дэх Рамалла хотод Хамас ба Израилын хооронд барьцаалагдсан хоригдлуудыг солилцох хэлэлцээрийн үеэр Палестин хоригдлуудыг сулласны дараа хүмүүс эсэргүүцэж байна. REUTERS/Ammar Awad/” гэсэн тайлбар өгчээ.

Тус тайлбараас гэрэл зургийн тайлбарт дан ганц тухайн зурагт буулгасан орчин, эх сурвалжийн талаар биш тухайн бичвэрийн сэдэв асуудал болоод бичвэрт тусгагдсан баримт мэдээллээс сонирхолтой хэсгээр нь өгч болдог болохыг харж болох юм.

### Дүгнэлт

Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэгдэж буй гэрэл зургууд нь энгийн нэгэн зураг биш, хөдөлшгүй баримт төдийгүй түүгээр дамжуулан олон нийтэд мэдээллийг дамжуулж байдаг. Тиймдээ ч мэдээллийн гэрэл зургийг тайлбартай хэвлэн нийтлэх шаардлага тулгарна. Гэтэл Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд нийтлэгдэж буй гэрэл зургууд нь бараг бүхэлдээ тайлбаргүй байгаа нь цаашид онцгой анхаарч үзэх тулгамдаж буй асуудал болоод байна. Бид мэдээллийн сайтуудын гэрэл зурагт ажиглалт хийгээд дараах дүгнэлтэд хүрэв.

- Цахим сэтгүүл зүй эрчимтэй хөгжиж буй өнөө үед мэдээллийн сайтууд нь гэрэл зураг, ялангуяа түүний тайлбарт ач холбогдол өгдөггүй болох нь судалгаанд хамруулсан “ikon.mn”, “news.mn”, “gogo.mn” сайтаас харагдаж байна. Мөн түүвэр байдлаар ажигласан бусад мэдээллийн сайтад ч гэрэл зургийн тайлбар гэдэг зүйл байхгүй байгаа нь хөндөж, дэвшүүлэх чухал асуудал болжээ.
- Мэдээллийн гэрэл зурагт тайлбар өгөхгүй, ач холбогдол бага өгч байгаа нь редакцад ажиллаж буй фото сэтгүүлчдийн ур чадвар тааруухан байгааг ч мөн илтгэж байна.
- Түүнчлэн мэдээллийн сайтуудад нийтлэгдэж буй гэрэл зургуудын дийлэнх нь хуучирсан, архивын гэрэл зураг байгаа нь ажиглагдлаа. Үүнээс үүдэн гэрэл

зургийн тайлбар орхигдож байгааг ч үгүйсгэхгүй юм. Тиймээс редакцууд фото сэтгүүл зүйн ач холбогдлыг нэмэгдүүлэх хэрэгтэй гэсэн дүгнэлт гарч байна.

- Эцэст нь хэвлэл мэдээллийн байгууллагууд мэдээллийн гэрэл зургийг хэвлэн нийтлэх өөрийн стандартыг бий болгох хэрэгцээ шаардлага байна гэж дүгнэв.

## The Significance of Captions in News Photography

**Enkhbat Chuluunbaatar**

*Ph.D, Lecturer of the Department of Journalism, Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia*

**Abstract:** Journalistic prose, accessible to individuals with diverse educational backgrounds, resonates effectively in the realm of photojournalism. When presenting a photograph that encapsulates the essence of an event alongside informative content, it is essential to include the name and a descriptive caption beneath the photo.

Whether the image features a prominent personality, a specific location, or a compelling portrait, this practice elevates factual details into meaningful and impactful information. Encountering a magazine cover image without accompanying captions for the first time often sparks surprise or prompts a page turn. Therefore, it is a lapse for the photojournalist to overlook the inclusion of a comprehensive photo description.

Individuals possessing discerning skills directly engage with the visual narrative, and the absence of contextual explanation renders the invested time and effort ineffectual. The failure to provide elucidation implies a depreciation of the photographer's meticulous work. Once a photo description is published, it stands as an immutable record, underscoring the irrevocable nature of this crucial aspect.

**Keywords:** Photography with no captions, photo journalism, photojournalist, content of photography significance

### Ном зүй

- Мелвин Менчер. (1996). *Сэтгүүл зүйн бичлэгийн үндэс*. Улаанбаатар.  
Баярсайхан, Б. (2009). *Монгол хэлний хураангуй тайлбар толь бичиг*. Улаанбаатар.  
Болд-Эрдэнэ. Б. (2004). *Сонины дизайн*. Улаанбаатар.  
Хэвлэлийн Хүрээлэн. (2005). *Фото сэтгүүл зүй*. Улаанбаатар.  
Крис Гаткум. (2013). “Гэрэл зураг сонирхогчдод зориулсан гарын авлага. Улаанбаатар.

Михайэл Халлер. (2015). Мэдээллийг нягтлахуй. Улаанбаатар.  
<https://www.hermannsonslife.org/>  
<https://contrastly.com/>  
<https://www.alamy.com/>  
<https://photo-journalisme.org/>  
<https://nieman.harvard.edu/>